



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

## ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР

Б корпус, Засгийн газрын IX байр,  
Энхтайваны өргөн чөлөө 16, Баянзүрх дүүрэг,  
Улаанбаатар хот, 13381  
Утас/Факс: (976-51) 26 00 62  
Цахим шуудан: info@spa.gov.mn  
Цахим хуудас: www.spa.gov.mn

*2023. 07. 05 № A-1/2969*  
таний *-ны № -т*

ТЕНДЕРТ ОРОЛЦОХЫГ  
СОНИРХОГЧ ЭТГЭЭДЭД

### Г Тодруулгын хариу хүргүүлж тендерийн баримт бичигт өөрчлөлт оруулах тухай

Тус газраас зарласан ТХААГ/202304057 дугаартай II.2.4.1-4 "Улаанбаатар-Лүн чиглэлийн 101.7 км авто замыг 4 эгнээ болгон өргөтгэн шинэчлэх төслийн ТЭЗҮ, зураг төсөл /Төв, Лүн сум/ зураг, төсөл боловсруулах зөвлөх сонгох тендер шалгаруулалтад оролцохыг сонирхогч этгээдээс тодруулга авах хүсэлт ирүүлсэнтэй холбогдуулан дараах хариуг хүргүүлж байна. Үүнд:

Сонирхогч этгээдээс ирүүлсэн тодруулга	Тодруулгын хариу
1. Зам, тээврийн хөгжлийн яамны 2023 оны 04 сарын 10-ны өдөр баталсан ТЭЗҮ-06/23 ба А33Т-04/23 дугаартай ажлын даалгаваруудын эхний хэсэгт дээрх замын ("ШИНЭ ХАРХОРУМ" хот чиглэлийн авто зам) ТЭЗҮ-г боловсруулахаар, харин А33Т-04/23 дугаартай ажлын даалгаварт мөн замын ТЭЗҮ, зураг төслийг боловсруулахаар давхардуулан дурдсан нь ойлгомжгүй байна. Эдгээрийн алиныг нь ямар ажилд баримтлах?	Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын баталсан 2023 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн ТЭЗҮ-06/23 дугаар Техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын даалгаврыг Улаанбаатар - Хархорум чиглэлийн авто замын техник эдийн засгийн үндэслэл боловсруулах гэж ойлгоно.
2. ТЭЗҮ-06/23 дугаартай даалгаварын ерөнхий зүйл болон хамрах хүрээнд дурдсанаар бол Улаанбаатараас шинэ Хархорум хот хүртлэх замын ТЭЗҮ-г боловсруулахаар ойлгогдож байна. Энэ зөв эсэх?	Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын баталсан 2023 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А33Т-04/23 дугаартай Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах ажлын даалгавар нь Техник, эдийн засгийн үндэслэлийг үндэслэн инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах бөгөөд Монгол Улсын Шадар Сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд 2023 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн А/18 тушаалд тусгагдсан нэршлээр ажлын даалгаварт туссан болно.
3. Хэрэв тийм бол тухайн даалгаврын 5-д заасан олон төрлийн хайгуул, судалгаа, үнэлгээ, урьдчилсан хэмжилт ба төсөллөлт, хөрөнгө оруулалтын нийгэм, эдийн засгийн шинжилгээ хийж, тэдгээртэй холбогдолтой тайлангуудыг бэлтгэхэд гол үндэслэл нь болох замын урт болон эхлэл, төгсгөлийн цэгийг тодорхой болгох шаардлагатай,	Техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах хугацаа нь инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын хугацаанд багтсан болно. Тендерийн баримт бичигт заасан хугацааг баримтлана.
4. Уг ажлын даалгаварт ТЭЗҮ-г боловсруулах хугацааг огт тусгаагүй тул дээрх ажлуудтай нягт уялдуулан эцсийн хугацааг тогтоож өгөх, Мөн энэ даалгаварт Лүнгийн замын зургийг 2023 оны 3 дугаар улиралд багтаан гүйцэтгэнэ гэсэн нь ТЭЗҮ-г боловсруулах хугацаатай яаж уялдаж байгаа вэ? Өөрөөр хэлбэл, төсөллөлтийн техникийн гол шийдлүүдийн хувьд харилцан уялдаатай эдгээр 2 ажлыг нэгэн зэрэг гүйцэтгэж, 6 сарын дотор дуусгана гэдэг маш эргэлзээтэй тул энэ асуудлыг хэрхэх вэ? Нөгөө талаас Лүнгийн замын ТЭЗҮ, зургийг энэ оны 12	

132329694

ТХААГ-2023-А4

сарын 15-ны дотор дуусгахаар тендерийн баримт бичигт тусгасаныг баримталсан ч ер нь боломжгүйг харгалзах.	
5. А33Т-04/23 дугаартай даалгаварт Лүн хүртлэх замыг 4 эгнээ болгон өргөсгөхөөр заасан нь хэрэв ТЭЗҮ-ээр өөр байхаар гарвал хэрхэн шийдвэрлэх.	Техник, эдийн засгийн үндэслэлээр гарсан үр дүng захиалагчтай зөвшилцэж зураг төслийг боловсруулна.
6. Уг даалгаврын 14-д дурдсаны дагуу -геодезийн ажлын тайланг “Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар”-т хүргүүлж, бүртгүүлсэн тухай бичиг авах гэхэд тухайн газар нь манайд хамааралгүй гээд өгдөггүй асуудлыг хэрхэх.	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 1/1133 тоотыг хавсаргав.
7. Мөн дээрх 14 дүгээрт байгаа Хяналтын цэгүүдийн ерөнхий төлөвлөлтийн зураг төсөл гэдэгт юуг ойлгох эсэх талаар дурдсан байна.	Улсын сүлжээний өндрийн хяналтын цэгүүдээс тэдгээрийн түвшний хэмжилтийг нивелир ашиглан Балтын тэнгисийн өндрийн системд битүү нүүлтээр хэмжиж холбоно, Реперүүдийг холбох өндрийн хэмжилтийн хүлцэх алдаа нь $10\sqrt{L}$ mm байна. Хэмжилтийн зай L-г км-ээр тооцно.
8. Тендерийн баримт бичгийн ТӨХ-ийн ТӨ31.5-д Захиалагчийн оролцоо, үзүүлэх дэмжлэг, байр, тоног төхөөрөмж: Үгүй гэсэн байгаа учраас Жишиг маягт 3.3-ын Захиалагчийн үзүүлэх үйлчилгээ, мэдээлэл, байгууламжийн хувьд: гэсэн хэсгийг бөглөхгүй орхиж болох уу?	Маягт 3.3-ын Ажлын даалгавар болон захиалагчийн үзүүлэх үйлчилгээ, мэдээлэл, байгууламжийн талаарх зөвлөхийн санал, зөвлөмжийг ирүүлэх шаардлагагүй.

Тендер шалгаруулалтад тодруулга гаргасантай холбогдуулан Зөвлөх үйлчилгээний тендерийн баримт бичигт дараах өөрчлөлтийг оруулж байна. Үүнд:

ТӨ3 5.5-д *Тендер хүлээн авах эцсийн хугацаа: 2023 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн 11.40 цагт.*

ТӨ3 5.6-д *Тендерийн нээлт хийх огноо цаг нь: 2023 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн 11.50 цагт.*

Хавсралт: 1 хуудастай.





МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
**ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,  
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗАР**

15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг.  
Барилгачдын талбай 3, Утас: 26 02 03.  
Факс: (976-11) 32 26 83, И-мэйл: info@gazar.gov.mn

2023.05.26 № 11133  
таний -ны № -т

Хуулийн хэрэгжилтийг  
хангуулах тухай

2022 онд хийгдсэн авто замын зураг төсөл боловсруулах ажлын хүрээнд хийгдсэн геодезийн сүлжээ болон байр зүйн зургийн үр дүнг Геодези, зураг зүйн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2. дахь хэсэгт заасны дагуу Геодези, зураг зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд хүлээлгэн өгнө үү.

Мөн авто замыг улсын комисст хүлээн авахын өмнө замын гүйцэтгэлийн зуэгийг хийлгэж 1:25000-1:100000-ны масштабтай байр зүйн зурагийг шинэчлэх бсломжоор хангана уу.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ж.БАТСАЙХАН

1523001228

ЗАМ, ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН  
ЯАМНЫ АВТОЗАМЫН  
БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ  
ЗОХИЦУУЛИХ ГАЗАРТ